



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 382

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын ерөнхий прокурорын газрын харьяа Прокурорын газрын хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 2 нэрийн, нийт 32,000,000.00 (гучин хоёр сая) төгрөгийн балансын үнэ, 29,499,999.98 (хорин есөн сая дөрвөн зуун ерэн есөн мянга есөн зуун ерэн есөн төгрөг ерэн найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, хавсралтад заасан Прокурорын газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай

2.1. Орон нутгийн өмчийн газрын төлөөлөгчийг оролцуулан, үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.4. Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2025 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001640
16-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны ... дугаар сарын ... ны/ний өдрийн
... дугаар тогтооллын хавсралт

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗРЫН ХАРЪЯА ПРОКУРОРЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийг эзэмшигч байгууллагын нэр	Хөрөнгийн нэр, төрөл, арал, улсын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Дуудлага худалдаагаар худалдах доод үнэ (төгрөг)
1	Дорноговь аймгийн Замын Үүд сум дахь Сум дундын прокурорын газар	NISSAN Patrol (Ниссан патрол) маркийн 0970ДГН улсын дугаартай, JN1TCSY61Z0581155 арлын дугаартай суудлын автомашин,	2011/2011	22,000,000.00	22,000,000.00	-	15,000,000.00
2	Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь Сум дундын прокурорын газар	Toyota land kruiser (Тоёото 7461УКР улсын дугаартай, JTMH09JX04000857 арлын дугаартай автомашин,	2007	10,000,000.00	7,499,999.98	2,500,000.02	30,000,000.00
НИЙТ ДҮН							
				32,000,000.00 (гучин хоёр сая)	29,499,999.98 (хорин есөн сая дөрвөн зуун ерэн есөн зуун ерэн есөн төгрөг ерэн найман мөнгө)	2,500,000.02 (хоёр сая таван зуун мянга хоёр мөнгө)	45,000,000.00 (дөчин таван сая)